

## МОНГОЛЧУУДЫН ГАЗРЫН ЗУРАГИЙН УЛАМЖЛАЛ, ТҮҮНИЙГ СУДАЛСАН ТОЙМ, ҮР ДҮН

### Ц. Шагдарсүрэн

1. Уламжлалт монгол газарын зурагийн тухай ерөнхий тойм
  2. Монгол газарын зурагийн тархац
  3. Уламжлалт монгол газарын зурагийг судалсан байдал
  4. Уламжлалт монгол газарын зурагийн баримт хийгээд монголчуудын газарзүйн мэдлэгийн талаархи гүжир сурталчилгаа
- Хавсралт: 1. холбогдох зураг сэлт, 2. холбогдох албан баримт сэлт

1. Аливаа улс үндэстэний нэгэн адил монголчууд ч өвөг дээдсийнхээ үеэс эргэн тойрон, орчин ахуйгаа танин мэдэх тэмдэглэн авах гэсэн эрмэлзэлтэй байсан нь мэдээж бөгөөд үүний баталгаа баримт түүхийн нугачаанд үрэгдэн үгүй болсон нь үлэмж ч бас шууд болон дам холбогдох мэдээ сэлт, биет хэрэглэгдэхүүн үлдэж ирсэн нь нэлээд буй ажээ. Энэ бүхэнд үндэслэж монгол газрын зургийн уламжлалын талаар товч танилцуулая.

Уламжлалт монгол газрын зурагт шууд болон дам холбогдох баримт сэлтийн цаг хугацааг авч үзвэл, бидний өнөөдрийн мэдэх хэрээр хамгийн эртнийхи нь “Хожуу Хан улсын түүх”-нээ тэмдэглэгдэн үлдсэн, Хүннү нарын газрын зурагт шууд холбогдох мэдээ христусын тоолол (х. т.)-ын 46 онд хамаарах бөлгөө<sup>1</sup>. Бас Их Монгол улсын үед монголын худалдаачид тухайн цагт европ дахинд нүдний гэм болж байсан хятад шаазан эдлэл зарангаа газар орон, зам харилцаа, цайз бэхлэлтийн зураг хийж заншилан явдаг байсан тухай мэдээ байдаг гэж академич Ринчен багштан нэг бус удаа ярьж байсан боловч тэр үед тодруулан асуугаагүйдээ одоо амаа барьдаг.

---

<sup>1</sup> Фан Е, История Поздней династии Хань, глава 79, Повествование о южных Сюнну, -Материалы по истории Сюнну (по китайским источникам) вып. II. Предисловие, перевод и примечания В.С.Таскина, Москва, 1973, стр. 70; Ts. Chagdarsürüng, La connaissance géographique et la carte des Mongols, SM [Studia Mongolica], Tom 3 (II), fasc. 20, Ulaanbaatar, 1976, pp. 345-370; Ц. Шагдарсүрэн, Монголчуудын утга соёлын товчоон, Улаанбаатар, 1991, 60-78; Ц. Шагдарсүрэн, Монголчуудын утга соёлын товчоон, Нэмэн зассан хоёрдугаар хэвлэл, Улаанбаатар, 2003, 15-28.

### Ц. Шагдарсүрэн

МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль  
Shandastu@yahoo.com

### Фүтаки Хироши, Камимүра Акира, Э.Равдан, Л.Чулуунбаатар

Монгол орны газрын зураг болон газар нутгийн нэрийн судалгааны асуудлууд  
МУИС пресс хэвлэлийн газар, Улаанбаатар, 2012, ISBN 978-99962-72-59-2

Бидний үед бие бодотой хүрэлцэж ирсэн болоод 1937 оны байдлаар Улсын номын сангийн Азийн ангид хадгалагдаж байсан, энэ хэр хамагийн олон нэгж бүхий, газрын зургийн товъёг жагсаалт<sup>2</sup>, мөн гадаадын олон монголч эрдэмтэний холбогдох бүтээлийн мэдээ зангид үндэслэн Монголчуудын зурж хэрэглэж ирсэн уламжлалт газрын зургийн төрөл зүйлийг үзвэл

- Газарын ёсны тэмдэглэл буюу Газарын хөрсний дүрэмт сав хэмээх дэлхийн хэмжээний буюу бөмбөрцөгийн хэлбэртэй Юан улсын үеийн бүтээл,
- тивийн буюу бүс нутгийн,
- улсын,
- тодорхой мөрөн голын сав нутгийн,
- аймгийн:
  - нэг аймгийн,
  - нутаг савлаж хил нийлсэн хэд хэдэн аймгийн,
- хязгаарын,
- хошуу болон шавийн:
  - нутаг савлаж хил нийлсэн хэд хэдэн хошууны,
  - шинээр нутаг таслан өгсөн хошуу болон шавийн,
- хот суурины:
  - хот суурины тодорхой нэг хэсгийн,
  - тухайн хотын захиргаанд тусгайлан нутаг заан өгсөн,
- хүрээ хийдийн,
- өртөөний:
  - нийт өртөө замын,
  - тодорхой чиглэлийн өртөөний,
  - тодорхой аймгийн нутаг дээрхи өртөөний,
  - тодорхой хэдэн өртөөний,
  - өртөө болон харуулын нэгдсэн,
- харуулын:
  - нийт харуулын,
  - тодорхой аймгийн дэвсгэр дээрхи харуулын,
  - тодорхой хэдэн харуулын,
  - хилийн овооны,
  - харуул болон өртөөний нэгдсэн зураг,
  - [мөн хязгаар нутгийн хошууны хилийн гадагш хандсан овоо нь харуулын зурагт давхар хамаарна]

гэх зэрэг олон төрөл зүйлтэй байжээ.

Монгол газрын зургийн орон зайн хэмжигдэхүүнийг үзвэл дөрвөн зүг, дөрвөн зовхис, дээд, доод гээд нийт **арван зүг**-ийг хамарна. Тийм ч учраас монголчуудын монгол хэл, монгол бичгээр тайлбар үйлдсэн одот тэнгэрийн зураг бидний судлагдахуунд бас хамаарна гэж бодож байна. Зүг чигийг илэрхийлэх хэмжээсийн бага нэгж нь тойргийг 48 хуваасны нэг буюу **7.5 хэм** байсан ажээ<sup>3</sup>. Зураг үйлдэх дүрэм болон зурагийн хэмжээсийн тухайд нэгэдмэл баримтлал байсан бөгөөд түүнийг нийтээр дагаж ирсэн байх ба харьцангуй хожуу, Богд хаант Монгол улсын *Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль Зүйлийн бичиг-*

<sup>2</sup> [Я. Цэвэл], *Монгол улсын номын сангийн Азийн ангид бүхий монгол ангийн бичмэл ба дармал номын бичигүүдийн бүртгэл*, (БНМАУ-ын Шинжлэх Ухааны Хүрээлэн, Монголын хувьсгалын арван зургаан жилийн ойд зориулан нийтлэв), Улаанбаатар, Монгол Улсын 27-р он [ (Монгол бичигээр) 261 тал]: Газарзүй ба эдийн засагийн анги [1-514 нэгж]: 90-152-р тал.

<sup>3</sup> Ts. Chagdarsüring, *La connaissance géographique et la carte des Mongols*, SM, Tom 3 (II), fasc. 20, Ulaanbaatar, 1976, pp. 345-370; Ц. Шагдарсүрэн, *Монголчуудын утга соёлын товчоон*, Улаанбаатар, 1991, 60-78; Ц. Шагдарсүрэн, *Монголчуудын утга соёлын товчоон*, Нэмэн зассан хоёрдугаар хэвлэл, Улаанбаатар, 2003, 15-28.

т тусгайлан хуульчилаж тодруулан тогтоож өгчээ<sup>4</sup>. Үүнд: Зургийг зохиохдоо монголчуудын **өмнө** зүгийг эрхэмлэдэг уламжлалаар морин зүгийг өмнөд этгээд болгодог (хулгана зүгийг хойд этгээд болгодог) нь одоогийн нийтээр дагаж буй газрын зургийн зарчимтай яг тохирно. Хэмжээс (масштаб)-ын тухайд дээрхи хуулиар нэгэн **ямх** (0, 32 м)-ад 25 *газар* (*газар* – 362 *алд* [нэг *алд* – 1,6 м] буюу 576 м)-г багтаана, *гучинзургаан алд*-ыг нэгэн **хувь**, *хувь*-д үл хүрэхийг **алд**-ын тоогоор хэмжинэ... хэмээн заасан бол түрүү үеийн зурагт нэг *ямх*-ад 20 *газар* багтаан зурж байсан баримт тухайн зурагийн тайлбарт харагддаг.

Монгол газрын зураг нь бодот дүрслэгдэхүүнтэйгээ илүү ойр, шашин сурталын сэтгэлгээ тусаагүй, дүрслэх байдал нь хятад, солонгос зэрэг ази дахинаа үйлдэж байсан уламжлалт зурагтай зарчимын хувьд үндсэндээ төстэй, хэдийгээр Монгол газар Бүддийн шашин үлэмж нөлөөтэй байсан боловч домогийн сэтгэлгээ үлэмж Энэхэг-төвөд зургийн уламжлалыг аваагүй гэж хэлэх бүрэн үндэстэй<sup>5</sup>.

2. Тухай тухайн цагийн хууль дүрэмийн дагуу газар нутгийн зурагийг тодорхой хугацаанд шинэчилдэг байсан тул монголчуудын үйлдсэн нийт засаг захиргааны нэгж бүрийн болон шинэ байгуулсан нэгжийн уламжлалт газрын зураг давхардсан тоогоор чамлахааргүй олон байжээ. Тэгээд ч нэлээд хэсэг нь Монгол Улс болон Азид БНХАУ, Япон, Европод ХБНГУ, Польш зэрэг олон ороноо хадгалагдсаар, судлагдахуун болсоор, хэвлэгдсээр бөлгөө.

Монгол Улсын тухайд цагийн саалт, уламжлалаа үгүйсгэдэг түрүү нийгэмийн харгайгаар уламжлалт монгол газрын зургаас үрэгдэн үгүй болсон нь бас ч олон. Гэвч ахмад үеийн эрдэмтэдийн хүчин зүтгэлээр амжин цуглуулсан уламжлалт монгол газрын зураг Улсын номын сан, Улсын архив болон Гадаад харилцааны яамны архив, Хязгаарын газрын музей, орон нутгийн музейн үзмэр, сан хөмөргөд хадгалагдсаар байна. Бас соёл түүхээ хайрладаг хувь хүмүүсийн цуглуулгад ч нэлээд зураг буй. Тус улсад хадгалагдаж буй монгол газрын зургийн санг авч үзвэл тухайн үед олон улсын номзүйд баримтлаж байсан “*аравт*”-ын тогтолцоогоор монгол газар анх зохиож 1937 онд хэвлэгдсэн, зохиогчийн нэр нь гаднаа бус оршилдоо байдаг *Бүртгэл*<sup>6</sup>-ийн мэдээгээр нэгэн дор хамгийн олон зурагтай нь Улсын номын сан байсан гэж үзэж болно. Үүнд:

**Цаг хугацааны хувьд:**

Манж Чин улсын сүүлийн зургаан хаан:

Сайшаалт-ерөөлт [丙辰-仁宗(嘉慶) 1796-1821],  
Төр-гэрэлт [辛巳-宣宗(道光) 1821-1851],  
Түгээмэл-элбэгт [辛亥-文宗(咸豐) 1851-1862],  
Бүрэнт-засагч [壬戌-穆宗(同治) 1862-1875],  
Бадаргуулт-төр [乙亥-德宗(光緒) 1875-1909],  
Хэвт-ёс [己酉-溥儀(宣統) 1909-1911]

болон Монгол улсын

Богд хаант Монгол Улс (1911-1921),  
Монгол Улс,  
БНМАУ-ын эхин үе хүртэл

буюу уулаар нэрлэсэн аймагтай болсон, нийтдээ 130-гаруй жилийг хамарсан,

*Засаг захиргаа* буюу *орон зайн хувьд*:

1. Түшээт хан, Сэцэн хан, Засагт хан, Сайн ноён хан аймаг, хошуу, хязгаар нутаг, шинээр нутаг таслан олгосон хошууны, Сэцэн хан болон Сайн ноён хан аймагийн

<sup>4</sup> *Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль Зүйлийн бичиг*, Улаанбаатар, 1995, 180-р тал.

<sup>5</sup> Л. Н. Гумилев (в соавторстве с Б. И. Кузнецовым), *Две традиции древнетибетской картографии*, - Ритмы Евразии. Эпохи и цивилизации, Москва, 1993, стр. 438- 456.

<sup>6</sup> [Я. Цэвэл], *Монгол улсын номын сангийн Азийн ангид бүхий монгол ангийн бичмэл ба дармал номын бичигүүдийн бүртгэл*, (БНМАУ-ын Шинжлэх Ухааны Хүрээлэн, Монголын хувьсгалын арван зургаан жилийн ойд зориулан нийтлэв), Улаанбаатар, Монгол Улсын 27-р он [(Монгол бичигээр) 261 тал]: Газарзүй ба эдийн засагийн анги [1-514 нэгж]: 90-152-р тал.

нутаг дахи харуул, хилийн овооны, өртөөний, хот суурины болоод тухайн хот суурины тодорхой хэсгийн ...

2. *Өвөр зургаан чуулганы зураг, Ордосын нутагийн зураг, Цахарын баруун дөрвөн хошууны зураг, Зостын чуулганы зүүн хошууны нутгийн уул ус зэргийг бүртгэсэн зураг, Ширээт хүрээний лам нарыг захирагч Рабжимба лам Агваанбалданы хошууны нутагийн зураг ...* зэрэг Өвөр монголын

нутаг дэвсгэрийн гэх мэтээр хуваан үзэж болохуйц, нийтдээ 356 газрын зураг, 136 зургийн өгүүлэл цэс нэгэн дор хадгалагдаж байсан ажээ. Энэ бол ерөнхий хуваарь. Цаашид нэгбүрчилэн үзэх бөгөөс илүү нарийн хуваарь, ялгаа харагдах болно. Бас уг номзүйд бүхий таван зуу шахам баримтаас уламжлалт монгол газрын зурагт холбогдох олон үл мэдэгдэхүүнийг олж тодруулж болно.

1937 онд Улсын номын сангийн хөмөргөд байсан тэдгээр зураг болоод зургийн цэс тэргүүтэнийг 2011 онд Японы Васеда Их сургуулийн Монголын судлалын хүрээлэнгээс эрхилэн нийтлүүлсэн *Үндэсний номын сангийн монгол гарбичмэлийн бүртгэл*<sup>7</sup> дэхи *Газрын зураг* болон *Нутгийн цэс*-ийн жагсаалтай тоо ширхэгийн хувьд харьцуулан үзвэл нэмэгдэж үүнд: газрын зураг 433, нутгийн цэс 194-д хүрч нийтдээ 627 нэгж болсон нэн таатай мэдээ байна. Харин зураг, цэс тус бүрээр нарийвчлан хөөж тулган үзэх бөгөөс чухам ямар зураг, цэс нэмэгдсэн хийгээд өөр ямар нэгэн өөрчлөлт орсон эсэх нь тодорхой болох болно.

3. Уламжлалт монгол газрын зургийн судлагаа анх гадаадад эхлэн гарч<sup>8</sup>, харьцангуй сүүл үеэс ХБНГУ<sup>9</sup>, Японд<sup>10</sup> үлэмж эрчимжисээр байна. Харин уугуул монголдоо төдий өргөн далайцтай гарч байгаагүй нь үндэснийхээ сэтгэлгээ, түүхэн уламжлалыг үгүйсгэдэг социалист хэмээх Монголын тухайн үеийн нийгэмтэй холбоотой. Гэвч ор хоосон байсангүй. Уламжлалт монгол газрын зургийн талаар 1969 онд олон нийтэд анх танилцуулсан хүн бол Б. Гончигдорж гэдэг багш болно<sup>11</sup>. Энэхүү өгүүлэлийг бичигч монголчуудын үйлдэж ирсэн газрын зураг, түүний уламжлал, үйлдэх арга тэргүүтнийг *зурагзүй* (Cartography)-н талаас нь 1976, 1977, 1991, 2003 онд франц, монгол хэлээр эрдэм шинжилгээ болон олон нийтийн анхааралд удаа дараа толилуулсан бөгөөд<sup>12</sup> гадаадын судлаачид ч хэрэгсэн сонирхож зарим хэсэг нь тэр хэвээрээ зураг хөрөгтэйгээ эшлэл болж орсон байдаг<sup>13</sup>.

Уламжлалт монгол газрын зургийн судлагааны өнөөдөрийн ерөнхий төлөв байдлыг үзвэл хоёр гол чиглэл харагдана. Нэгд, биет зургийг газарзүй, зурагзүй, түүх, хэлний

<sup>7</sup> *Catalogue of the Mongolian Manuscripts in the National Library of Mongolia*, Compiled by Ch. Narantuya & D. Enkhtungalag, Edited by Tachibana Makoto, - Bulletin of Waseda Institute for Mongolian Studies, A Separate Volume, Waseda University, 2011, [104 pp.], see. 14-27; 28-33 pp.

<sup>8</sup> Владимирцов Б.Я., *Объяснения к карте Северо-Западной Монголии*, - ИИРГО [Известия Императорскаго Русскаго Географическаго Общества], Том. XLVII, 1911, стр. 491-495; Walter Fuchs, *The "Mongol Atlas" of China*, Monumenta serica, Monograph VIII, Peiping, 1946; Joseph Kler, *A propos de cartographie mongole*, - Bulletin de la Société Royale Belge de Géographie, Fars I-II, 1956. pp. 26-51.

<sup>9</sup> W. Heissig, *Über mongolische Landkarten*, - Monumenta Serica, 9, Peiping, 1944, pp. 123-173; W. Heissig unter Miterbeit von Klaus Segaster, *Mongolische Handschriften, Blockdrucke, Landkarten* – VOHD [Verzeichnis der Orientalischen Handschriften in Deutschland], Band I, Wiesbaden, 1961; Magadburen Haltod, *Mongolische Ortsnamen*, Teil I, (Mongolische Manuskript - karten in Faksimilia) - VOHD, Supplementband 5.1, Wiesbaden, 1966; Walther Heissig, *Mongolische Ortsnamen*, Teil II, (Mongolische Manuskriptkarten in Faksimilia) -VOHD, Supplementband 5.2, Wiesbaden, 1978; Walther Heissig, *Mongolische Landkarten*, - Die Mongolen, Herausgeber W. Heissig, Claudius C. Müller, Munchen, ss. 268-271.

<sup>10</sup> H. Futaki & A. Kamimura (Editors), *Landscapes Reflected in Old Mongolian Maps*, TUFUS [Tokyo University of Foreign Studies], Tokyo, 2005.

<sup>11</sup> Б. Гончигдорж, *Монголчуудын газар зүйн зургийн түүхийн зарим асуудалд*, -ШУАМ [Шинжлэх Ухааны Академийн мэдээ], 1969, N. 1, 54-60-р тал.

<sup>12</sup> Ts. Chagdarsüring, *La connaissance géographique et la carte des Mongols*, SM, Tom 3 (II), fasc. 20, Ulaanbaatar, 1976, pp. 345-370; Ц. Шагдарсүрэн, *Монголчуудын газарзүйн мэдлэг, газрын зургийн уламжлал*, - Шинжлэх ухаан амьдрал, Улаанбаатар, 1977, N. 1, 73-7.-р тал; Ц. Шагдарсүрэн, *Монголчуудын утга соёлын товчоон*, Улаанбаатар, 1991, 60-78-р тал; Ц. Шагдарсүрэн, *Монголчуудын утга соёлын товчоон*, Нэмэн зассан хоёрдугаар хэвлэл, Улаанбаатар, 2003, 15-28-р тал.

<sup>13</sup> Walther Heissig, *Mongolische Ortsnamen*, Teil II, (Mongolische Manuskriptkarten in Faksimilia) -VOHD, Supplementband 5.2, Wiesbaden, 1978: Einleitung, ss. XII-XV.

талаас нь судлаж хэвлэн нийтлэсэн ажил гарсаар байна. Энэ нь Монголын өнгөрсөн үеийн түүхийн судлагаанд найдвартай баримт хэрэглэгдэхүүн болж өгнө. Бас монголчуудын газарзүй, зурагзүйн уламжлалт мэдлэгийн судалгаа гэсэн үг. Нөгөө нь, уламжлалт монгол газрын зурагт үндэслэж Ази дахины олон ард түмний түүхэн газрын зураг үйлдэх арга барил, харилцан холбогдох асуудлыг илүүтэй анхаарч байна. Энэ нь нийгэм-соёлын харилцааны түүхтэй холбогдоно. Ийм ажлын жишээнд Масааки Сүгияама (Masaaki Sugiyama) профессорын нэр бүхий бүтээлийг дурдаж болно. Гол судлагдахуун нь *"Түүхэт газар ороны нутаг дэвсгэр, муж хийгээд нийслэл хотын газарын зураг"* хэмээх дурсгал бөгөөд зохиогч **дэлхийн хэмжээний** уг зургийн учир холбогдолыг судлаад анх Юан гүрэнд үйлдэж, 1402 онд Солонгос газар дахин бүтээсэн, одоо Япон газар хоёр хувь хадгалагдаж байна хэмээн үзжээ<sup>14</sup>. Энэхүү зураг нь Ази дахины олон ард түмний соёлын харилцааг илтгээд зогсохгүй бичвэр нь монгол хэлээр хятад үсгээр байгаа тул угтаа *"Чингис хааны узуур (язгуур)"* гэдэг монгол нэртэй байсан гэж үздэг<sup>15</sup> *Монголын нууц товчоон* [元朝秘史], ... И-юй [... 譯語] маягийн толь бичгүүдийн нэгэн адил дундад үеийн монгол хэлний дорнод аялгууны баримтыг хятад галигаар тэмдэглэсэн шинэ баримт болохын хувьд монголын судлалд эрхим чухаг судлагдахуун болж өгнө. Бас Юан гүрэний үед (монголоор: *Газарын хөрсний дүрэмт сав* буюу *Газарын ёсны тэмдэглэл* [苦來亦阿兒子] гэдэг) дэлхийн хуурай газар болон усны хувь харьцааг орчин үеийн тооцоотой дүйхүйц зөв бодотой тэмдэглэсэн<sup>16</sup> дэлхийн бөмбөрцөг үйлдэхийн хажуугаар дэлхийн хэмжээний газрын зураг гаргаж байсаны баримт болж өгнө.

Профессор Э. Равдан монгол газар усны нэрийн цогц судалгаандаа уламжлалт монгол газрын зураг болон монголчуудтай түүхэн хэлхээ холбоо бүхий гадаад дахины газрын зурагт тэмдэглэгдсэн газар усны монгол нэрийг хэрэглэгдэхүүн болгон эрдэм шинжилгээний гүйлгээнд оруулсаар байна. Уламжлалт монгол газрын зураг нь тухай тухайнхаа үеийн хууль дүрмийг хэлбэрэлтгүй дагаж зохих шалгуурыг давсан байдаг тул хэн нэгний элдэв санаа зорилго шургалаагүй, түүхийн найдвартай баримт болж өгдөг, эрдэм шинжилгээний хувьд өвөрмиц судлагдахуун гэж үзэх бүрэн үндэстэй. Тэгээд ч түүхэн газарзүйн баримт болгон хэрэгсэж гэмээ нь хөдлөшгүй үндэслэл болж бас чадна.

Үүнээс гадна профессор О. Пүрэв уламжлалт монгол газрын зургийг улс төр-газарзүйн түүхэн баримт болох талаас нь судласан нь буй<sup>17</sup>.

4. Монголчуудын уламжлалт газрын зураг болон газарзүйн мэдлэгтэй холбоотой баримт сэлтээс үзвэл ялангуяа социализмын үед монголчууд *"хөмөрсөн тогоо"*-нд байгаа юм шиг, *"эмээлээсээ өндөр даваа давж үзээгүй, эхнэрээс өөр хүнийг тааж үзээгүй"* тул дэлхийг хавтгай, хөдөлгөөнгүй гэж үздэг, нутаг хошуунаасаа өөр газар орныг мэддэггүй, нар саран барихыг шашины үүднээс Рааху хэмээх амьтан залгисан гэж үздэг гэх мэтээр ертөнцийн явдалыг таниж мэдэлгүй ирсэн ... гэх мэтээр итгэл үнэмшил болтол бидэнд ойлгуулсан зүйлтэй огт нийцдэггүй билээ. Бас зарим хүн Монголд Буддийн шашины нөлөө үлэмж байсан тул Энэдхэг, Төвөдийн нөлөө монгол газрын зурагт байдаг байж магадгүй гэж таамагладаг ч чухамдаа Сүмбэр уулыг төв гэж үздэг эртний Энэдхэгийн уламжлалыг монгол газрын зургаас олохгүй<sup>18</sup>. Харин монгол газрын зурагаас уламжлалт *монгол зураг-т* хангай дэлхийг дүрсэлдэг зарчмыг төвөггүй олж харж болно.

<sup>14</sup> Masaaki Sugiyama, *World Maps originating in Asia*, - Changes in History: Real, Representative and imaginary, Collection of Papers and Abstracts on History I, Beijing Forum, 2005, pp. 15-29.

<sup>15</sup> F.W. Cleaves, *The Secret History of the Mongols*, Volume 1, Translation, London, 1982, pp. ix-ixiii.

<sup>16</sup> Walter Fuchs, *The "Mongol Atlas" of China*, - Monumenta Serica, Monograph VIII, Peiping, 1946, p. 5; Ts. Chagdarsüring, *La connaissance géographique et la carte des Mongols*, SM, Tom 3 (II), fasc. 20, Ulaanbaatar, 1976, p. 346; Ц. Шагдарсүрэн, **Монголчуудын утга соёлын товчоон**, Улаанбаатар, 1991, 60-61-р тал; Ц. Шагдарсүрэн, **Монголчуудын утга соёлын товчоон**, Нэмэн зассан хоёрдугаар хэвлэл, Улаанбаатар, 2003, 10-р тал.

<sup>17</sup> О. Пүрэв, *Монгол улсын түүхэн газарзүй*, Улаанбаатар, 2004.

<sup>18</sup> Л. Н. Гумилев (в соавторстве с Б. И. Кузнецовым), *Две традиции древнетибетской картографии*, - Ритмы Евразии. Эпохи и цивилизации, Москва, 1993, стр. 438- 456.

Гэтэл чухамдаа дэлхий ертөнцийг бөөрөнхий хэмээн дүрслээд зогссонгүй, хуурай газар, усны хувийг зөв тооцож байсан баримт байна. Энэ нь чухамдаа Колумба Америкийг нээхээс өмнө Америк тивийн газар нутгийн хэмжээ дамжааг сайн мэддэг байсаны баримт гэж үзэхэд эрхгүй хүргэнэ.

Их бичгийн хүн В. Инжаннашийн “*Бөмбөрцөгийн өгүүлэл*” хэмээх бүтээлээс үзэхэд “...газар дэлхийн байдлыг хэлбээс бөмбөрцөг адил. Нарны өөдлөн эргэж орчих нь наран хөдлөхгүй, газар дэлхий хөдлөж орчих болой...”<sup>19</sup>

гэсэн байдаг нь лавтайяа тэр үед орчин үеийн шинжлэх ухааны ойлголттой адил байсан гэсэн үг.

“*Хорин нэгт*” хэмээх монгол хэлний толь бичигийн дотор *наран, саран хиртэхийг*:

...*Наран, сараны явахуйд тушаалдагдаж халхлагдсаныг наран баримуй хэмээмүй...*

...*Саран, наранд эсэргүүцэлдэж газарын бараг сүүдэр тушаалдаж халхлагдсаныг саран баримуй хэмээмүй...*<sup>20</sup>

хэмээн тайлбарласан байдаг. Үүнчилэн олон зүйлийг жагсаан дурдаж болно. Наад зах нь монгол түмэний ардын дуунд

...*Орчлон(г) гэдэг бөөрөнхий  
Эргэж хөрвөж байдаг...*

хэмээн өгүүлдэг нь бас нэгийг бодогдуулахад эрхгүй хүргэнэ.

Нэгэнт үнэн байдал, хөдлөшгүй баримт ийм байтал түрүүчийн нийгэмийн үед үндэсний уламжлалыг судлаж мэдэхийг хаан боож ирсэн нь хоцрогдсон Монгол зөвхөн социализмын үеэс хөгжсөн гэдэг хуурамч итгэл үнэмшил суулгах гэсэн зорилготой шууд холбоотой болох нь тодорхой харагддаг.

Энэ мэт дээр дурдсан наад захын баримтаас үзэхэд уламжлалт монгол газрын зургийг судлах нь зөвхөн монголын судлалын хүрээнд газарзүй, зурагзүйн уламжлалт мэдлэг, монгол хэлний хөгжилийн үе шат, түүх, соёл боловсролын гадаад харилцаа,... зэрэг олон салбараар хязгаарлагдахгүй монгол түмэнээс дэлхийн соёл боловсролд оруулсан хувь нэмэр, хүн төрөлхитөний сэтгэлгээний түүхийн асуудал болж байна.

<sup>19</sup> Инжаннаши, *Бөмбөрцөгийн өгүүлэл*, - Эрдэнэтогтох, Орчин үеийн монголын алдарт уран зохиолчид, Тэдний түүвэр зохиолыг дагалдуулав. Хөхэхот, 1981, 59-р тал; Төвгэрэлт, *Сүвд тана сацарсан уянга* (Инжаннашийн шүлэг зохиолын сонирхол), Хөхэхот, 1992, 592-596-р тал; В. Инжаннаши, “*Дүгрэг хөрөгийн өгүүлэл*” - Бариачин овогт Дархан, Монгол соёлын сурвалж өгүүлэхүүн, Хөхэхот, 1999, 108-131-р тал.

<sup>20</sup> *Qorin nigetü tayilburi toli*, Kökeqota, 1977, 193, 536.

**Монголчуудын газрын зургийн уламжлал,  
түүнийг судалсан тойм, үр дүн**

**Уламжлалт монгол газарын зурагийн тухай ерөнхий тойм**

Зурагийн төрөл зүйл

**Дэлхийн бөмбөрцөг:**

苦來亦阿兒子。漢言地理志。其制以木為圓毬。七分為水。其色祿。三分為土地。其色白。畫江河湖 脉絡貫串於其中。畫作小方井， 以計幅員之廣袤。道里之遠近。

Дандаа шансаны монгол орчуулга:

“...Газарын ёсны тэмдэглэл буюу Газарын хөрсний дүрэмт сав-ыг хийсэн байдал гэвэл модоор дүгрэг бөмбөг үйлдэж долоон хувий нь ус болгожээ; түүний нь өнгө ногоон. Үлдэх гурван хувийг газар шороо болгожээ. Түүний өнгө цагаан бөгөөд мөрөн, гол, тэнгис, далайн судсыг түүний дотор хэлхэж тоолжээ. Өчүүхэн зохистой худаг (ам дөрвөлжин нүд бүхий тор<sup>II, III</sup>) зурж үйлдээд газар дэлхийн агуу ба газрын хол ойрыг тэмдэглэжэхүй...”<sup>1</sup>

Walter Fuchs авгайн англи орчуулга нь:

“*K'u-lai-i a-erh-tzu* (苦來亦阿兒子) denotes in Chinese a representation of the Earth. It has been manufactured by the following methods: a round ball has been made of Wood; seven parts of it represent water, the colour of which is green, and three parts - land, the colour of which is white. Streams, rivers, lakes, and seas have been marked in such a way as to extend their lines over the whole ball; [in addition], small squares have been made in order to make it possible to calculate the size of regions and the distances of roads” (From “Yuan-shih”)<sup>2</sup>

Газарын ёсны тэмдэглэл буюу Газарын хөрсний дүрэмт сав  
(苦來亦阿兒子) хэмээх дэлхийн бөмбөрцөгийн талаархи  
Юан улсын судар (元史)-ын 48-р дэвтэр дэхи баримт  
**Тивийн буюу бүс нутгийн зураг:**




<sup>1</sup> Юан улсын судар, 48-р дэвтэр, Дандаагийн орчуулга, гар бичмэл.

<sup>2</sup> Walter Fuchs, *The "Mongol Atlas" of China*, - Monumenta Serica, Monograph VIII, Peiping, 1946, p. 5.

”Түүхэт газар ороны нутаг дэвсгэр, муж хийгээд нийслэл хотын газарын зураг” хэмээх дурсгал бөгөөд Японы Масааки Сүгияама (Masaaki Sugiyama) профессор **дэлхийн хэмжээний** уг зургийн учир холбогдолыг судлаад анх Юан гүрэнд үйлдэж, 1402 онд Солонгос газар дахин бүтээсэн, одоо Япон газар хоёр хувь хадгалагдаж байна хэмээн тэмдэглэжээ<sup>3</sup>.

Улсын хэмжээний газрын зураг:




Монгол атласт буй Солонгосын (хойгийн) газрын зураг<sup>4</sup>

<sup>3</sup> Masaaki Sugiyama, *World Maps originating in Asia*, - Changes in History: Real, Representative and imaginary, Collection of Papers and Abstracts on History I, Beijing Forum, 2005, pp. 15-29.

<sup>4</sup> Walter Fuchs, *The "Mongol Atlas" of China*, - Monumenta Serica, Monograph VIII, Peiping, 1946, p. 42.




Тодорхой мөрөн голын сав нутгийн зураг:




Хэрлэн, Орхон мөрний сав газрын зураг<sup>5</sup>

<sup>5</sup> Walter Fuchs, *The "Mongol Atlas" of China*, - Monumenta Serica, Monograph VIII, Peiping, 1946, p. 48.


Хошуу болон шавийн зураг:



Сэцэн хан аймагийн Мэргэн засаг, улст туслагч гүн  
Цэрэнвандуйбавуудоржийн хошууны зураг



Сэцэн хан аймгийн Мэргэн засаг, улст туслагч гүн Цэрэнвандуйбавуудоржийн хошууны зурагийн цэс



Сэцэн хан аймгийн Мэргэн засаг, улст туслагч гүн Цэрэнвандуйбавуудоржийн хошууны одоогийн байршил

**Хот суурины зураг:**



Их хүрээ байгуулах эхн үеийн зураг



Их хүрээний зураг

Хүрээ хийдийн зураг:




Сайн ноён хан аймагийн Чин сүзэгт номун хан хутагтийн хүрээний зураг



Сайн ноён хан аймагийн Ламын гэгээний хүрээний зураг


Өртөөний зураг:



Нийт өртөөний зураг




Дээрх зургаас Их хүрээ орчимыг таслан үзүүлсэн хэсэг




Хүрэннээс хойшхи 11 өртөөний зураг

Харуулын зураг:




Сэцэн хан аймагийн харуулын зураг




Түшээт хан аймагийн Орос зүгийн харуулын зураг





**Одон тэнгэрийн зураг:**





Монголын уламжлалт газрын зургийн суурь:







Дөрвөн зүг, найман өнгө, найман өнцөг, дөрвөн зовхис бүгд 24, тэдгээрийн завсар гээд нийтдээ 48 буюу 7,5 хэм болно.

Уламжлалт монгол зурагт хангай дэлхийг хэрхин дүрслэдэг баримтаас:



Марзан хэмээх Балдуугийн Шаравын  
“Монголын нэг өдөр” хэмээх зургийн хэсэг

Монгол уламжлалт газрын зургийн талаархи энэхүү өгүүлэлд баримт, эшлэл авсан зарим ховор ном зохиолоос



Я. Цэвэлийн 1937 онд нийтлүүлсэн номзүйн бүтээл

[Энэ бүртгэлд тухайн үеийн байдлаар нэгэн дор хадгалагдаж бүхий монгол газрын зураг болон түүнд хамаарах хамгийн олон баримт мэдээ буй]

1. [Бадаргуулт төр (1871-1908) хаан (1875-1909)-ы үеийн баримт]

**Зарлигаар тогтоосон зураг зурсан хэмжээний дүрэм,  
басхүү зураг өгүүллийн дүрмийн тухай**

...Зургийг зурах хэрэг зүйл, хянан тогтоосон зургийн дүрэм, басхүү зургийн өгүүллийн дүрмийг долоон сарын арванд хичээнгүйлэн **Дээр** үзүүлж давшуулсугай хэмээн айлтгасанд **Зарлиг ёсоор болго хэмээв.**

...Зургийн доторхи өнцөг хувааж зурахад мужийн захирагч хэмээгч өнцөг тутам зуун газар болгоно. Фү жилийн тинхим, Эфү-гийн зураг хэмээгч өнцөг тутам тавин газар болгоно. Эфү-гийн зураг хэмээгч өнцөг тутам арван газар болгоно.

Хязгаар хэлхээ хэмээгч агуу урт тэгшгүй өнцгийн тоонд дүрэм хэмжээ баримтлуулбал болохгүй.

...Жич: газар-ын тоог төсөвлөн бодоход хүн явбал зам муруй мэт, шувуу нисвэл ёсоор чигчийн адил, байцааваас: бидний улсын Хо-вей-гийн зурсан Иой ханы тогтоосон газар зургийн үг Ин улсын Фай Сиёо-гийн ун, ван хэмээх зургийн журам Хо-лин-и нарын сийлсэн Дайчин улсын нэгэн болгон нэгэдхэх газар орны зураг даруй тэр мэт дүрмийн ёсоор сийлсэн бөлгөө.

Аймаг хошууны нутгийн доторхи газар орны байдал төлөвийг байцаан үзэж зах хэлхээг нарийн чанд болгож нэгэн дөрвөлжинд хэдэн газар болохыг тохируулан байдал хэмжээг цаг улиралын тооны хүрдэний арван хоёр жил, найман өнгө, дөрвөн зовхис бүхий хорин дөрвөн зүгийн морин үсгийг өмнөд болгож уул газрыг өвөр этгээдээс зурахад тус тус нутгийн зах хэлхээг аль газраас үүсгэж аль газарт чигч хүргүүлэн хэдэн газар аль зүг зовхис тийш болох хэмжээ тоог тодорхойлон гаргаж нарийн тодорхой чигч үйлдэж зургийг хамтаар ... энэ оны долоон сарын шинийн нэгэнд манай газарт мэдүүлэн хүргэн ирүүлээд хянан шийтгэхэд бэлтгүүлсүгэй ...

Бадаргуулт төрийн 16 он, илүү 2 сарын 22.

[УТГА (– Улсын түүхийн төв архив), Бадр. 1-13-82]

2. [Богд (1869-1924) хаант Монгол Улс (1911-1921)-ын үеийн баримт]

...Өгүүлэл нь дөрвөлжин хэмжээ нэг ямхын дотор хорин газар, хадыг аядуулах буюу хуучин удаагаар зурна. Хотыг ... энэ мэт зурна. Хүрээ сүмийг мөн хэвээр зурна. Яам тамгын газрыг хэлтрөгтэй монгол гэр мэт зурна. Олон засаг ба захиргааны суусан газрыг гэр бөгөөд үүдэвч майхантай мэт зурна. Байшин орон болвол тэр ёсоор зурна. Тариаланг ... энэ мэт зурна. Уурхайг ... энэ мэт зурна. Овоог ... энэ мэт зурна. Хуурай замыг шар өнгөөр зурна. Төмөр замыг ... энэ мэт зурна. Төмөр утас (=холбооны утас<sup>II, III</sup>)-ыг ... энэ мэт зурна. Цөм нэр бичнэ. Гадуур өмнөд хойд дөрвөн зүгийг захад дотогиши хандуулан заан бичнэ. Худагийг ... энэ мэт зурна. Алиас аль хүртэл хэдэн газар болох ба мөн тойронг цөм улаанаар зурна хаа хязгаар нийлсэн(ий)г бичнэ. Давст нуурыг ... энэ мэт зурна. Мөрөн голыг аль зүгээс аль зүг урассан тэр зүг хөх өнгөөр зурна. Онгоцыг ... энэ мэт зурна. Модыг мод, дэрсийг дэрс мэт зурна. Нуур ба гол булаг усыг цөм хөх өнгөөр зурна. Элс ба говь шил газрыг бүдэг ягаан өнгөөр зурна. Бэлчээр газрыг ногоон өнгөөр зурна ...

Олон-аа өргөгдсөний 3-р он 9 сарын 19

[УТГА (– Улсын түүхийн төв архив), А/Л. 1-13-80]

**Тэмдэглэх нь:**

Дээрхи хоёр баримтаас үзэхэд төстэй болон уламжласан зүйл байгаа ч ялгаа зөрөө нэлээд харагдана. Үүнд:

Манжийн үед хэнд зориулж үзүүлэхээс шалтгаалан зургийн хэмжээс өөр өөр байсан, зурагт тэмдэглэх таних тэмдэг буюу зургийн илэдхэл төдий л тодорхой бус байсаныг харж болно.

Богд хаант монгол улсын үед газрын зураг үйлдэх нэгэдмэл нэгэн журам буй болсоноос гадна зургийн **илэдхэл** буюу таних тэмдэг нь илэрхий монгол ахуйг тусгасан, түрүү түрүү үеийнхээс илүү нарийн болсон байдал тодорхой харагдана.

**3. [“Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль Зүйлийн бичиг” хэмээх цааз хуулийн 45-р дэвтэрт Нутагийн хэрэгийн хууль-д Нутагийн зураг үйлдүүлэх нь гэдэг тусгай зүйл ангийн баримтаас]**

Нэгэн зүйл: Олон засаг хошууны нутаг газар орны хэмжээ байдалыг нарийн тодорхой зурж тойрон овоо тэмдэг байгуул. Цөм цаг улиралын тооны бичигийн найман хүлэл, арванхоёр жилийн хүрдэний доторхи найман зүг, арванхоёр салаа, хориндөрвөн зүгийн морин үсэгийг өмнөхи болгож уул овоонд толгойг хойш хандуулан зурагтун. Гурван зуун жаран нэгэн алд газарыг нэгэн газар, гучинзургаан алдыг нэгэн хувь, хувьд үл хүрэхийг алдын тоогоор хэмжиж хоринтаван газарыг нэг ямхын хэмжээнд багтааж дөрвөлжин хүснэгт татаж зүүн этгээд хөх барс, хөхөгчин туулай, өмнө этгээд улагчин могой, улаан морь, баруун этгээд цагаан бэчин, цагагчин тахиа, хойд этгээд харагчин гахай, хар хулгана, зүүн өмнө оролго, шар луу, баруун өмнө ээвэргүү, шарагчин хонь, баруун хойд этгээд зогсолт, шарагчин үхэрийн зүг чигийг үзэж зах нийлэх засаг хошуу лугаа хязгаар уулзах газарт байгуулсан овооны нэр, хоорондын хэмжээ, мөнхүү зүг лүгээ тохиолдуулан хэмжиж, тодорхой цэс бичиж Дотоод Яамнаа мэдүүлэн ирж хянан байцаалгагтун!<sup>1</sup>

---

<sup>1</sup> Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль Зүйлийн бичиг, Улаанбаатар, 1995, 180-р тал.